

**МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН
МАТЕРИАЛ**
А хувилбар

Хугацаа 60 минут

Нийт – 20 оноо

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

Хэрлэнгийн хөндийд хурдан морь тарлаж байв. Тал нутгийн зун идэрхнээрээ, голын өмнөх гүвээнүүд хөвчийг нь тавьсан нум шиг тэнийлгэн цэнхэрлэж, агь бууралтсан газраас айраг цагаа үнэртэнэ. Морь тарлаж байм өдөр өө. Морьтой ардын үр сад гэсэндээ сэтгэл хөөрөн хөл хөнгөрчээ. Уяа тойрон гийнгоолох хүүхдүүдийн дуу чихэнд бус зүрхэнд хадаад Хэрлэнгийнхээ энэ хөндийд ялгуум сайхан мориор давхиж нэг үзвэл нас залуужих мэт санагдана. Уяан дээр үрээ насны цагаан бор морь хазаар даран зогсоно. Хурдан морь шинжих эрдэм даанчиг байхгүй гэлээ ч би ухаанаараа дүүрэн мэлтэгнэх нүдийг нь хараад энэ лав түрүүлэх морь байна. Ийм хөлөг унасан хүн уужимхан сэтгэлтэй байлгүй яах вэ? гэж бодлоо. Сэтгэл будангуйран бухимдах цагт “Эр хүний дотор эмээлтэй хазаартай морь багтана” гэсэн үг юутай үнэн билээ.

1. Дээрх эхэд дэвшүүлсэн асуудал буюу гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг эхээс олж бичээрэй.

\2 оноо \

2. Эхээс шалтгааны утгат өгүүлбэрийг ялган, шалтгаан, үр дагаврыг ялган бичээрэй. \ 2 оноо

Шалтгаан

Үр дагавар:

3. “Хурдан морь шинжих эрдэм даанчиг байхгүй гэлээ ч би ухаанаараа дүүрэн мэлтэгнэх нүдийг нь хараад энэ лав түрүүлэх морь байна.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг солин найруулахад тохирох үгийг сонгоорой. 2 оноо

А. учир

Б. тэгвэл

В. хэдий ч

Г. эсвэл

4. Аль нь эхэд байгаа “хөнгөрчээ” гэсэн үгийн язгуурын утга вэ? 2 оноо

А. хөнгөр- хөнгөн болох гэсэн утгатай үйл үг буюу идэвхгүй язгуур

Б. хөнгөр- хөнгөн болох гэсэн утгатай үйл үг буюу идэвхтэй язгуур

В. хөнгөн- хүнд гэсний эсрэг утгатай нэр үг, идэвхтэй явзгуур

Г. Хөнгөн- хүнд гэсний эсрэг утгат нэр үг, идэвхгүй язгуур

5. Онцолсон үгтэй адилхан дүрэмтэй бичигдсэн үгийг олоорой. 2 оноо

Морьтой ардын үр сад гэсэндээ сэтгэл хөөрөн хөл **хөнгөрчээ**...

А. түүчээ

Б. түүжээ

В. шингэрчээ

Г. тасалжээ

6. Үндэсний бичгээс кирил бичигт хөрвүүлээрэй.

\ 5 оноо \

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠡᠯ, ᠪᠢᠴᠢᠭ, ᠤᠷᠠᠨ ᠵᠣᠬᠢᠣᠯ ᠬᠢᠴᠡᠭᠡᠯᠢ ᠠᠨᠭᠢ ᠳᠡᠪᠰᠢᠬᠤ ᠰᠢᠯᠭᠠᠯᠲᠤ ᠮᠠᠲᠢᠷᠢᠯ
ᠠ ᠬᠤᠪᠢᠯᠠᠷ

7. Ж. Барамсай “Цүнхтэй инээд” өгүүллэгийн дүр болох шог зураач Цайдам гуайн хэлсэн үгээс иш татаж, шог зургийн талаар үзэл бодлоо идэрхийлэн бичээрэй. Үгийн тоо (30- 40), 5 оноо

МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Б хувилбар

Хугацаа- 60 минут

Нийт – 20 оноо

Дараах эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

АЙМХАЙ ХҮН АРАВ ҮХДЭГ

Байлдааны салбарт баатар хүн нэг үхдэг бол аймхай хүн арвантаа үхдэг гэдэг. Энд баатар эр зоригтой хүн, хулчгар аймхай хүн хоёрыг жишин харьцуулж, аймхай хулчгар занг шүүмжилсэн болох нь илэрхий.

“Хүн нэг л үхэхээс хоёр үхэхгүй” гэсэн бас нэг хэлц байдаг. Гэтэл дээрх хэлцэд “Арав үхдэг” хүний тухай хэлжээ. Ямар хүн арав үхдэг вэ? гэвэл “Аймхай хүн” гэж хариулна. Хүн биеэр нэг л удаа үхэх байтал арван удаа үхэх гэж юуг хэлж байна. Энэ чинь хүний сэтгэлээр үхэхийг хэлж байна. Чухамдаа биеийн үхэл нэг бол сэтгэлийн үхэл хэд ч байж болно. Тэгэхлээр аймхай хүний сэтгэл ямар хөөрхийлөлтэй, арчаагүй сул дорой, зан чанар нь ямагт шантрамтгай, халирамхай, туйлбаргүй байна. “Айсан хүнд аргал хөдөлнө” гэдэг.....

..... Аймхай хулчгар зантай хүн алив бэрхшээлийн өмнө өвдөг сөхрөх нь олон, ажлаас халшрах шантрахдаа амархан байдаг. Тэгвэл аймхайн эсрэг эр зоригтой хүн элдэв бэрхээс эмээхгүй, ажлын хүндээс халширдаггүй, юунаас ч айдаггүй тул ямар ч ажлыг хийж бүтээж байдаг. “Эр хүн зоригтой бол чоно чацга алддаг” гэсэн хэлц үг буй. /Д.Баттогтох/

1. Эхийн гол санааг илэрхийлсэн хэлц үгийг олж бичээрэй. \ 2 оноо \
2. “Байлдааны салбарт баатар хүн нэг үхдэг бол аймхай хүн арвантаа үхдэг гэдэг “ гэсэн өгүүлбэрийн утгын харьцааг зөв тодорхойлоорой. \ 2оноо\
А. ойролцоо Б. эсрэг В. зүйлчилсэн Г. төсөөт
3. “сэтгэл” гэсэн үг шилжсэн утгаар ороогүй хэсгийг олоорой. 2 оноо
А. Сэтгэл зүй Б. Сэтгэлийн үхэл В. Сэтгэл гаргах г. Сэтгэл сэтмрэх
4. Эхэд заахын тийн ялгалаар хэлбэржсэн үг хэд байна вэ? 2 оноо
А. 3 Б. 4 В. 5 Г. 6
5. Зөөлний тэмдэг “и” болох дүрмийг зөрчих тохиолдол бүхий үгийг олоорой. 2 оноо
А. соль- лоо Б. тахь- ж в. шуугь- н г. горь- гүй

ᠶᠢᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ
ᠶᠡᠰᠡᠭᠡᠨ ᠶᠡᠬᠡᠨ

6. Дараах эхийг хөрвүүлэн бичээрэй. 5 оноо
 \ 5 оноо \
7. Д. Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэгийн Жамьянгийн оронд байсан бол Жав гуайд хүүгийнх нь талаар юу гэж хэлэх байсан талаар өөрийн санааг 40- 50 үгэнд багтаан бичнэ үү. 5 оноо